

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨМЖ (2018 он)

1. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201812/01 PWC, Honeywell компаниудад. /Safety recommendation 201812/01. To Pratt & Whitney Canada and Honeywell/.

PW127 серийн хөдөлгүүрт суурилагддаг НМУ эд ангийн задаргааны үед зөвхөн үзлэгээр хязгаарлагдалгүй холхивчийг солих шаардлагыг эд ангийн техник үйлчилгээний зааварт (СММ 73-20-61) тусгах, холхивч солих үечлэлийг хөдөлгүүр үйлдвэрлэгчийн техник үйлчилгээний зааварт тусгагдсан шаардлагатай уялдуулан тогтоох

2. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201812/02 ИНЕГ-т. /Safety recommendation 201812/02. МСАА/.

Орон нутгийн нисэх буудлуудад шатахуун хадгалах, агаарын хөлөгт сумлах үйлчилгээг ИНД-144 дүрмийн дагуу гэрчилгээжүүлэн үйл ажиллагаа, чанарын хяналтын тогтолцоог олон улсын иргэний нисэхийн байгууллагын Doc 9977-д тусгагдсан зөвлөмж, стандарт болон үндэсний MNS 6591:2016 стандартад нийцүүлэх арга хэмжээг авах

3. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201812/03 ИНЕГ-т. /Safety recommendation 201812/03. МСАА/.

Шатах тослох материалын шинжилгээ хийж ИНЕГ-ын харьяа лабораториудыг ИНД-144 дүрэм, холбогдох стандартуудад заагдсан шаардлагатай шинжилгээг бүрэн хийх, хүний хүчин зүйлийн нөлөөг багасгасан орчин үеийн шинжилгээний тоног төхөөрөмжөөр хангах арга хэмжээг авах